



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/77

Чингис хот

Халдвараас урьдчилан сэргийлэх  
зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Орон нутгийн хэмжээнд коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын голомттой нутаг дэвсгэрээс иргэдийг татан авсантай холбогдуулан хийсэн нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээний дүнг хэлэлцсэн аймгийн Онцгой комиссын 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдэл аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өндөр байгаа тул 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цагаас 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хот хоорондын болон орон нутгийн хооронд тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг хязгаарласугай.

2. Хүнсний дэлгүүр, эмийн сан, шатахуун түгээх станц, ус түгээх цэгээс бусад бүх төрлийн худалдаа үйлчилгээ болон архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг дээрх хугацаанд түр зогсоосугай.

3. Цагаан сарын баяр, амралтын өдрүүдэд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн орох, гарах болон сум, хот тосгоны доторх тээврийн хэрэгслийн болон иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, эргүүл хяналт шалгалт зохион байгуулж, хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Б.Батсайхан/, сумдын Засаг дарга, хот тосгоны Захирагч нарт, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

4. Төрийн байгууллагууд дээрх өдрүүдэд ажлын тусгай горимд шилжиж /байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр тодорхой тооны албан хаагчийн хязгаар тогтоон, дотоод зохион байгуулалт хийх/ ажиллахыг аймаг сумын Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгаж, хязгаарлалт тогтоохгүй хэвийн ажиллах байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

231010237

2.

5. Өмнөдэлгэр сумын нутаг Бурхан халдун хайрхан, Мөрөн сумын нутаг Өндөрхаан хайрхан болон сумдын тахилгатай уул, овооны чиглэлийн хөдөлгөөнийг дээрх хугацаанд хязгаарлаж ажиллахыг сумын Засаг дарга, хот тосгоны Захирагч нарт, тус хөдөлгөөний хязгаарлалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

6. Дээрх өдрүүдэд сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдүүд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хүч хэрэгслийг томилгоожуулж, бэлтгэл бэлэн бэлэн байдлыг ханган, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн 2021 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрүүдэд аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
... дугаар сарын ... өдрийн ... /77  
дугаар захирамжийн хавсралт



Хязгаарлалт тогтоохгүй хэвийн ажиллах байгууллага

№	Байгууллагын нэр
1	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
2	Мэргэжлийн хяналтын газар
3	Хэнтий-Ус ХХК
4	Цахилгаан түгээх сүлжээ салбар
5	Цахилгаан холбоо
6	Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК
7	Эрүүл мэндийн газар
8	Зооноз өвчин судлалын төв
9	Уламжлалт анагаах ухааны төв
10	Онцгой байдлын газар
11	Шүүхийн шинжилгээний алба
12	Цагдаагийн газар
13	Нэгдсэн эмнэлэг
14	Тагнуулын хэлтэс
15	Авто тээврийн төв
16	Цахилгаан дамжуулах, түгээх байгууллага